

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. “Монголросцветмет” ХХК нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших XV-020521 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд геологи хайгуулын өрөмдлөгийн ажил хийж гүйцэтгэх, ажлын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж хамгаалах зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших XV-020521 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд геологи хайгуулын өрөмдлөгийн ажил хийж гүйцэтгэх, ажлын үр дүнгээр нөөцийн тооцоотой тайлан боловсруулж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэснээр компанийн харьяа Зэрэгцээ алтны үйлдвэрийн алт олборлолтыг нэмэгдүүлэх, үйлдвэрийн бүтээмжийг өсгөх, хүрээлэн буй орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
- Зөвлөх хуулийн этгээдийн санхүүгийн чадавхын мэдээлэл /сүүлийн 2 жилийн буюу 2017 оны санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх, 2018 оны баталгаажсан санхүүгийн тайланг нотариатаар гэрчлүүлсэн байх/,
- Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойших байдлаар/ ирүүлнэ.
- Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4. Сүүлийн 3 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар

5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас нэг хоногийн өмнө ажлын өдрийн 09-16 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгийг 2019 оны 03 дугаар сарын 19 – ний өдрийн 14 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

### **“Монголросцветмет” ХХК**

**Хаяг:** Улаанбаатар хот 51, ш/х – 002

Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө.

22-р хороо, “Монголросцветмет” ХХК-ын байр, 504 тоот,

И-мейл: [mailbox@monros.mn](mailto:mailbox@monros.mn).

Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-458675, 976-11-450060-152